



МОНГОЛ УЛС
ЁС ЗҮЙН ХОРООНЫ
ТОГТООЛ

2026 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Байгууллагын ёс зүй, сахилга хариуцлагын
үнэлгээний шалгуур үзүүлэлт, аргачлал
батлах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6.1, 11.6.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2024 оны “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” 27 дугаар тогтоолын 3 дахь хэсэг, Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын Байнгын хорооны 2023 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.5 дахь хэсэг, Засгийн газрын 2025 оны “Журам батлах тухай” 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 4.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Байгууллагын “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийг нэгдүгээр, “Үнэлгээ хийх аргачлал, хамрах хүрээ, дараалал”-ыг хоёрдугаар, “Тайлангийн маяг”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан шалгуур үзүүлэлт, аргачлалын дагуу тайланг салбар, нэгжийн түвшинд нэгтгэн жил бүрийн 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор тайлагнахыг төрийн болон нутгийн захиргааны байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтийг мэргэшил, арга зүйн удирдлагаар ханган, хяналт тавьж, нэгдсэн дүнг жил бүрийн 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор Ёс зүйн хороонд танилцуулахыг Ажлын алба (Н.Ганбаатар)-нд даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Ёс зүйн хорооны “Шалгуур үзүүлэлт батлах тухай” 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.АМАРТӨГС

152601008

Ёс зүйн хорооны 2026 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

ATA11169 8448906
9023111371

Байгууллагын “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”

№	Агуулга	Шалгуур үзүүлэлт	Үр дүн
1	2	3	4
1	Ёс зүйн тогтолцоог бэхжүүлэх үйл ажиллагаа (ЁЗЗУССГҮХ)	Байгууллагын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан (нөлөөллийн аян, хэлэлцүүлэг, өдөрлөг, уралдаан, сайн туршлага түгээх гэх мэт) бүтээлч ажлын тоо	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллагын соёлын зэрэг орчин төлөвшихөд ахиц гарна.
2		Батлагдсан сургалтын агуулгын хүрээнд тухайн жилд 2-оос доошгүй зохион байгуулагдсан сургалтад хамрагдсан нийт албан хаагчийн хувь	Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн талаар мэдлэг ойлголт дээшилж, ёс зүйн хэм хэмжээг мөрдөх хандлага төлөвшинө.
3		Байгууллагын эрсдэлийн үнэлгээний түвшин (хамрагдсан хувиар)	Ёс зүйн эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт сайжирч, зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.
4	Удирдах албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Удирдах албан тушаалтнуудын ёс зүйн чиглэлээр сургалтад хамрагдсан хувь	Удирдах албан тушаалтны ёс зүйт манлайлал, хариуцлага дээшилнэ.
5		Ёс зүйн дэд хорооны гишүүдийн чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа (сургалт, урамшуулал, баталгаа)	Байгууллагын Ёс зүйн дэд хорооны чадавх дээшилнэ.
6		Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүний тогтвортой ажиллагаа	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн хараат бус, тогтвортой, үр нөлөөтэй ажиллах нөхцөл бүрдэнэ.
7		Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийн дагуу ёс зүйн зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийн хувь	Ёс зүйн зөрчилд хариуцлага тооцох механизм сайжирч, шийдвэрийн хэрэгжилт, сахилга хариуцлага дээшилнэ.
8		Нийтэд ил тод байршуулсан Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны тайлан, ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийн тоо	Мэдээллийн ил тод байдал сайжирч, иргэдийн төрд итгэх итгэлийг дээшлүүлэх нөхцөл бүрдэнэ.
9	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Ёс зүйн дэд хорооны гишүүдийн зохион байгуулсан зөвлөгөө, мэдээлэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тоо	Төрийн албан хаагчдын Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн талаарх мэдлэг, ойлголт нэмэгдэж, ёс зүйн зөрчил гарах эрсдэл буурна.
10		Ёс зүйн асуудлаар ирүүлсэн гомдол, мэдээллийн шийдвэрлэлт (дүгнэлт)-ийн хувь	Хуульд заасан хугацаанд шуурхай, шударга шийдвэрлэх нөхцөл бүрдэнэ.
11		Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг эс зөвшөөрч гаргасан гомдлын тоо	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтэд хяналт тавьж, Төрийн албан хаагчийн эрхийг хангах боломж бүрдэнэ.
12		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системийн ашиглалт, дүгнэлт, шийдвэрийн бүртгэл, тайлагналт	Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын нэгдсэн цахим сан бүрдэж, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг цахимаар төлөвлөн, тайлагнаж, ажил хөнгөвчилнө.

Ёс зүйн хорооны 2026 оны 07 дугаар
сарын 06-ны өдрийн 03 дугаар тогтоолын
хоёрдугаар хавсралт

ATA11169 8448906
9023111371

ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ, ХАМРАХ ХҮРЭЭ, ДАРААЛАЛ

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

1.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ыг тус тус удирдлага болголоо.

ХОЁР. ЗОРИЛГО

2.1.Энэхүү аргачлалын зорилго нь төрийн байгууллагын ёс зүй, сахилга, хариуцлагын төлөвшил, урьдчилан сэргийлэх болон соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, удирдах албан тушаалтны ёс зүйн манлайлал, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг нотолгоонд суурилан нэг мөр, харьцуулж болохуйц, жил бүр давтамжтайгаар салбар, нэгжийн түвшинд үнэлэхэд оршино.

ГУРАВ. ЗОРИЛТ

3.1.Байгууллагын “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийг 3 агуулгын хүрээнд 12 шалгуур үзүүлэлтээр 10 хүртэл онооны системээр үнэлэх үнэлгээний нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх зорилтыг тавилаа. Үүнд:

3.1.1.Ёс зүйн тогтолцоог бэхжүүлэх үйл ажиллагааг байгууллага, салбар, нэгжийн түвшинд ёс зүй, сахилга, хариуцлагын төлөвшлийг бэхжүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт, соён гэгээрүүлэх, нөлөөллийн арга хэмжээ болон эрсдэлийн үнэлгээний тайлагналтай уялдуулан үр дүн, нотолгоонд суурилан үнэлэх;

3.1.2.Удирдах албан тушаалтны ёс зүйн манлайллыг хэмжиж, ёс зүйн чиглэлээр хамрагдсан сургалт, Ёс зүйн дэд хорооны гишүүдийн чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа (сургалт, урамшуулал, баталгаа)-ны хэрэгжилт болон ёс зүйн зөрчилд хариуцлага тооцсон байдлыг бодитой үнэлэх;

3.1.3.Ёс зүйн дэд хорооны гомдол, мэдээллийн шийдвэрлэлт, Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системийн ашиглалт, бүртгэл, тайлагналыг үнэлэх.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭНИЙ ЗАРЧИМ

4.1.Хуульд нийцсэн байх-Үнэлгээ нь энэхүү аргачлалын 1 дүгээр бүлэгт заасан хууль тогтоомжийн хүрээнд хийгдэнэ.

4.2.Нотолгоонд суурилсан байх-Үнэлгээг зөвхөн баталгаажсан тайлан, төлөвлөгөө, Ёс зүйн бүртгэл, хяналтын дэд системийн бүртгэл, судалгааны үр дүн, холбогдох тушаал, шийдвэр, цахим нийтлэлийн холбоос зэрэг нотолгоонд үндэслэн өгнө.

4.3.Харьцуулж болохуйц байх-Ижил онооны шатлал, тайлангийн маягтаар харьяа салбар, нэгж, байгууллагыг үнэлнэ.

4.4.Шударга, хараат бус байх-Үнэлгээ өгсөн үндэслэл, эх сурвалжийг тодорхойлж, хараат бусаар үнэлгээг хийнэ.

ТАВ. ХАМРАХ ХҮРЭЭ, ДАРААЛАЛ

5.1.Байгууллагын “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн тайланг дараах байдлаар салбар, нэгжийн түвшинд нэгтгэн ирүүлнэ. Үүнд:

№	Байгууллага	Тайлбар
1	2	3
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар	- Хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд шууд харьяалах бусад байгууллага.
2	Монгол Улсын Их Хурлын Тамгын газар	- Хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд шууд харьяалах бусад байгууллага.
3	Монгол Улсын Их Хурлаас бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллага	- Аймаг, нийслэл, орон нутгийн нэгж, салбар, байгууллага; - Хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд шууд харьяалах бусад байгууллага.
4	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	- Хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд шууд харьяалах бусад байгууллага.
5	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар	- Хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд шууд харьяалах бусад байгууллага.
6	Төрийн захиргааны төв байгууллага (яамд)	- Засгийн газрын агентлагаас бусад шууд харьяалах улсын төсөвт үйлдвэрийн газар болон төрийн бусад байгууллага.
7	Засгийн газрын агентлаг	- Аймаг, нийслэл, орон нутгийн нэгж, байгууллага; - Шууд харьяалах улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн бусад байгууллага.
8	Аймгийн Засаг даргын Тамгын газар	- Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний төрийн байгууллага; - Сумын Засаг даргын Тамгын газар.
9	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	- Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний төрийн байгууллага; - Дүүргийн Засаг даргын Тамгын газар (дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд шууд харьяалах нэгж, төрийн байгууллагыг нэгтгэх); - Төсөвт үйлдвэрийн газар болон төрийн бусад байгууллага, салбар, нэгж.

ЗУРГАА. ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

№	Агуулга	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Авбал зохих оноо	Үнэлэх аргачлал
1	2	3	4	5	6
1	Ёс зүйн тогтолцоог бэхжүүлэх үйл ажиллагаа (ЁЗУССГҮХ)	Байгууллагын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан (нөлөөллийн аян, хэлэлцүүлэг, өдөрлөг, уралдаан, сайн туршлага түгээх гэх мэт) бүтээлч ажлын тоо	Удирдамж, тушаал, тайлан	1	4 ба түүнээс дээш-1 оноо, 3 бол 0.8 оноо; 2 бол 0.5 оноо; 1 бол-0.2 оноо; 0 бол 0 оноо. (улирал бүр 1 бүтээлч ажлаар тооцно)
2		Батлагдсан сургалтын агуулгын хүрээнд тухайн жилд 2-оос доошгүй зохион байгуулагдсан сургалтад хамрагдсан нийт албан хаагчийн хувь	Нийт албан хаагчийн хамрагдалтын хувь	1	(2 ба түүнээс дээш сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо+нийт албан хаагчийн тоо)×100= хэрэгжилтийн хувь 90–100%-1 оноо; 80–89%-0.8 оноо; 60–79%-0.5 оноо; 40–59%-0.2 оноо; 40%-иас доош бол-0 оноо.
3		Байгууллагын эрсдэлийн үнэлгээний түвшин	Эрсдэлийн үнэлгээний тайлан	1	(Эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан салбар, нэгжийн тоо÷үнэлгээнд

		(хамрагдсан хувиар)			хамрагдах нийт салбар, нэгжийн тоо)×1= хэрэгжилтийн оноо.
Хэсгийн дундаж оноо				3	
4	Удирдах албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Удирдах албан тушаалтнуудын ёс зүйн чиглэлээр сургалтад хамрагдсан хувь	Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, бүртгэл	0.5	(Сургалтад хамрагдсан удирдах албан тушаалтны тоо÷нийт удирдах албан тушаалтны тоо)×0.5= хэрэгжилтийн оноо
5		Ёс зүйн дэд хорооны гишүүдийн чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа (сургалт, урамшуулал, баталгаа)	Төлөвлөгөө, тайлан	1	Сургалт зохион байгуулсан бол 0.3 оноо; урамшууллыг бүрэн олгосон бол 0.4 оноо; нийгмийн баталгаагаар хангасан бол 0.3 оноо.
6		Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүний тогтвортой ажиллагаа	Шийдвэр	0.5	Шинээр томилогдсон болон чөлөөлөгдсөн гишүүдийн тоо÷тайлант хугацааны эхний байдлаар нийт гишүүдийн тоо)×100=өөрчлөлтийн хувь 0–20% 0.5 оноо; 21–40% 0.4 оноо; 41–60% 0.3 оноо; 61–80% 0.2 оноо; 80%-иас дээш 0 оноо.
7		Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийн дагуу ёс зүйн зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийн хувь	Дүгнэлт, шийдвэр	1	(Хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийн тоо÷ёс зүйн дэд хорооны гаргасан нийт дүгнэлтийн тоо)×1= хэрэгжилтийн оноо (гомдол, мэдээлэл ирээгүй бол 1 оноо)
8		Нийтэд ил тод байршуулсан Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны тайлан, ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийн тоо	Байгууллагын цахим хуудас	1	Дэд хорооны үйл ажиллагааны тайланг нийтэд байршуулсан бол 0.5 оноо; хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг нийтэд байршуулсан бол 0.5 оноо; үгүй бол 0 оноо.
Хэсгийн дундаж оноо				4	
9	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Ёс зүйн дэд хорооны гишүүдийн зохион байгуулсан зөвлөгөө, мэдээлэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тоо	Дэд системийн бүртгэл	0.5	4 ба түүнээс дээш 0.5 оноо; 3 арга хэмжээ-0.4 оноо; 2 арга хэмжээ 0.3 оноо; 1 арга хэмжээ-0.2 оноо; 0 бол 0 оноо. (улирал бүр 1 арга хэмжээгээр тооцно)
10		Ёс зүйн асуудлаар ирүүлсэн гомдол, мэдээллийн шийдвэрлэлт (дүгнэлт)-ийн хувь	Дэд системийн бүртгэл	1	(Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн гомдол, мэдээллийн тоо÷нийт ирүүлсэн гомдол, мэдээллийн тоо)×1=хэрэгжилтийн оноо (гомдол, мэдээлэл ирээгүй бол 1 оноо)

11		Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг эс зөвшөөрч гаргасан гомдлын тоо	Дэд системийн бүртгэл	1	Дүгнэлтийг эс зөвшөөрсөн гомдлын тоо+нийт дүгнэлтийн тоо) $\times 100$ = хэрэгжилтийн хувь 0–20% 1 оноо; 21–40% 0.7 оноо; 41–60% 0.5 оноо; 61–80% 0.3 оноо; 80%-иас дээш 0 оноо. (гомдол, мэдээлэл ирээгүй бол 1 оноо)
12		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системийн ашиглалт, дүгнэлт, шийдвэрийн бүртгэл, тайлагналт	Дэд системийн бүртгэл	0.5	Дэд системийн ашиглалт бүрэн бол 0.5; дутуу бол 0.3; хангалтгүй бол 0 оноо.
Хэсгийн дундаж оноо				3	
Нийт оноо				10	

ДОЛОО.ҮНЭЛГЭЭНИЙ БАТАЛГААЖУУЛАЛТ

7.1.Байгууллага үнэлгээг Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системээр хийх бөгөөд дэд системд мэдээлэл, баримт оруулах, үнэлгээ хийх аргачлалын талаар зөвлөгөө, мэдээллийг Ёс зүйн хорооны Ажлын албанаас тухай бүр өгнө.

7.2.Нотолгоогүй шалгуур үзүүлэлтийн үр дүнгийн үнэлгээнд оноо өгөхгүй. Бичгээр болон нотлох баримтаар баталгаажаагүй мэдээлэл нь дангаараа онооны үндэслэл болохгүй.

7.3.Хугацаа хэтэрсэн тайланг хүлээн авч болох боловч үнэлгээ хийхдээ тайлагналын чанар, бүрэн байдлыг харгалзана.

7.4.Төрийн албан хаагчид холбогдох ёс зүйн гомдол, мэдээлэл гараагүй байгууллагад автоматаар бүрэн оноо өгөхөөс өмнө Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системийн “зөрчил, гомдол”-ын бүртгэл, тайлангийн баталгаажуулалтыг шалгана.

7.5.Нэг үйл ажиллагаагаар олон шалгуурт давхар оноо болгохгүй.

7.6.Байгууллагын өөрийн болон харьяа салбар, нэгжийн хэмжээнд хийсэн үнэлгээ дэд системийн үнэлгээнээс 1-ээс дээш оноогоор зөрвөл тайлбар, нотолгооны нэмэлт тулгалт хийж, эцсийн оноог баталгаажуулна.

7.7.Ёс зүйн ноцтой зөрчил, олон нийтийн итгэлд нөлөөлсөн үйл явдал гарсан хэдий ч тайланд тусгаагүй, хариу арга хэмжээ аваагүй, зохих журмын дагуу шийдвэрлээгүй бол холбогдох шалгуурын оноог бууруулах үндэслэл болно.

Ёс зүйн хорооны 2026 оны 07 дугаар
сарын 06-ны өдрийн 03 дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

ТАЙЛАНГИЙН МАЯГТ¹

ATA11169 8448906
9023111371

НЭГ. Товч танилцуулга²

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1. Ёс зүйн тогтолцоог бэхжүүлэх үйл ажиллагаа (ЁЗЗУССГҮХ):

2.2. Удирдах албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ):

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

¹ Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

² Байгууллага харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

